



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Нэр бүхий арилжааны банкуудад олгосон харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4, Монголбанк болон Сангийн яамнаас ирүүлсэн албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад нэр дурдсан арилжааны банкуудын харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн үйлчлэх хугацааг зөвхөн Монголбанкаар дамжуулан зохион байгуулах Засгийн газрын үнэт цаасны арилжаанд шууд бус оролцогчид зуучлалын үйлчилгээ үзүүлэх зорилгоор 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хүртэл сунгасугай.

2. Тогтоолын 1-д заасан тусгай зөвшөөрлийн үйлчлэх хугацааг сунгасантай холбогдуулан хууль тогтоомжоор хүлээсэн дараах үүргийг чанд биелүүлж ажиллахыг тогтоолын хавсралтад нэр дурдсан банкуудад үүрэг болгосугай.

1/ Хөрөнгө оруулагчид, үйлчлүүлэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журамд заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлэх.

3. Монголбанкаар дамжуулан зохион байгуулах Засгийн газрын үнэт цаасны нийлүүлэлтийн хуваарь, арилжааны тайланг тухай бүр нь Сангийн яам болон Монголбанкнаас зохих журмын дагуу авч Зохицуулалттай этгээдийн мэдээллийн санд бүртгэхийг Үнэт цаасны газар /Т.Цэрэнбадрал/-т үүрэг болгосугай.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2017 оны 03 дугаар сарын 10-ны  
өдрийн 49 дугаар тогтоолын  
хавсралт



Монголбанкаар дамжуулан зохион байгуулах Засгийн газрын үнэт цаасны арилжаанд  
шууд бус оролцогчид зуучлалын үйлчилгээ үзүүлэх тусгай  
зөвшөөрлийг сунгасан банкууд

Д/д	Банкны нэр	Регистрийн дугаар
1	Хаан банк	2693321
2	Голомт банк	2075377
3	Худалдаа хөгжлийн банк	2635534
4	Хас банк	2578697
5	Төрийн банк	5341469